

Бэлгийн болон Ахуйн хүчирхийллийн хохирогчдод зориулсан Цагаачлал, визийн мэдээлэл

Олон улсын оюутнууд болон судлаач оюутнууд цагаачлал, визийн статусын талаарх асуултаа цагаачлалын хуульчаас туслалцаа авахыг зөвлөж байна. Энэхүү баримт бичиг нь тухайн хуулийн зарим зүйл заалтын тухай тайлбарлах боловч эрх зүйн хүчинтэй зөвлөгөө болохгүй.

Би хүчирхийллийн хохирогч болсон. Миний цагаачлалын статус сургуульд нэвтрэх, үйлчлүүлэх эрхэд маань нөлөөлөх үү?

Үгүй. 1972 оны Боловсролын хуулийн нэмэлт (Title IX)-ийн 9-р зүйл, Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн Эсрэг хууль (VAWA)-иудад заасан хуулийн дагуу бэлгийн болон ахуйн хүчирхийллийн хохирогчид цагаачлалын статусаас үл хамаарч адил тэгш эрх эдлэнэ.

Сургуулийн дотоод эрүүл мэнд, зөвлөх үйлчилгээний тухай, мөн үзүүлэх хөнгөлөлтийн тухай дараах эх сурвалжаас үзнэ үү:

<https://1is2many.okstate.edu/>

Оюутны сахилгын арга хэмжээний тухай мэдээлэл:

<https://studentconduct.okstate.edu/code>

Гэмт хэрэг мэдээлсний улмаас сургууль тухайн хүнд хариуцлага хүлээлгэх юм уу ялгавартай харьцахгүй.

Бичиг баримттай, эсвэл бичиг баримтгүй хүн бусдын эсрэг эрүүгийн нэхэмжлэл гаргаж болох уу?

Болно. Бэлгийн болон ахуйн хүчирхийлэл, бэлгийн хамтрагчаа мөрдөж мөшгөх зэрэг хэргүүдийн талаарх мужуудийн эрүүгийн тодорхойлолтууд Жил тутмын Аюулгүйн Илтгэлд бий:

<https://police.okstate.edu/annual-security-reports>

Нэхэмжлэл гаргахтай холбоотой нэмэлт асуултуудыг илгээх:

Oklahoma State University Police Department, OSUPD
104 USDA Building, Stillwater, Oklahoma 74078
405-564-6523

<https://police.okstate.edu/>

1is2many@okstate.edu

Гэмт хэргийн хохирогчдод зориулсан тусгай виз, цагаачлалын статус байдаг уу?

Тийм. Бэлгийн болон ахуйн хүчирхийлэл, бэлгийн хамтрагчаа мөрдөж мөшгөх зэрэг хэргүүдийн хохирогчдод зориулсан визийн төрлүүд байдаг бөгөөд эдгээрт U, T зэрэг ангиллын виз багтана. Дэлгэрэнгүйг цагаачлалын хуульчаас лавлана уу.

U Виз	T Виз
Зарим гэмт хэргийн улмаас, тухайлбал бэлгийн хүчирхийлэл, гэр ахуйн хүчирхийлэл, хүчин, зодож занчих болон бусад төрлийн гэмт хэргийн улмаас бие эрхтэний болон сэтгэцийн ноцтой хохирол учирсан хохирогчид - Хохирогч/нэхэмжлэл гаргагч нь тодорхой ангилалд хамаарах гэмт хэргийн хохирогч байх, тухайн гэмт хэргийн мөрдөн байцаалт, илрүүлэлтэд тус болох боломжтой байх - Ихэнх тохиолдолд 4 жил хүчинтэй - Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг цагаачлалын хуульчтай зөвлөх ба дараах эх сурвалжаас үзнэ үү: http://www.uscis.gov/humanitarian/victims-human-trafficking-other-crimes/victims-criminal-activity-u-nonimmigrant-status/victims-criminal-activity-u-nonimmigrant-status	Хүний наймааны хохирогчдод зориулсан - Хүний наймааны үйлдлийг мөрдөн байцааж, буруутанд хариуцлага тооцоход хамтран ажиллах хууль сахиулах байгууллагаас гаргасан тодорхой саналыг хүлээн зөвшөөрөх (бие эрхтэн, сэтгэцийн хүнд гэмтлийн улмаас хамтран ажиллах чадваргүй байхаас бусад тохиолдолд), мөн хэрэв тухайн хохирогч/нэхэмжлэл гаргагчийг АНУ-с албадан гаргасан нөхцөлд амьдралын хүнд байдалд орох эрсдэлтэй гэдгийг нотлох боломжтой байх - Ихэнх тохиолдолд 4 жил хүчинтэй - Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг цагаачлалын хуульчтай зөвлөх ба дараах эх сурвалжаас үзнэ үү: http://www.uscis.gov/humanitarian/victims-human-trafficking-other-crimes/victims-human-trafficking-t-nonimmigrant-status

Сургуулийн хүрээнд нэмэлт мэдээллээр хангах алба ажилладаг уу?

, International Students & Scholars

250 Student Union, Stillwater, OK 74078

405-744-5459

<https://lcl.okstate.edu/iss/>

su-iss@okstate.edu

Олон Улсын Оюутан, Судлаач Оюутны Үйлчилгээний Алба цагаачлалын статусын талаар хэрэгтэй мэдээллээр хангаж ажилладаг. Визийн ангилал солиулах, эсвэл ердийн F-1 болон J-1 оюуны визийн ангилалд хамаарахгүй, эсвэл ажил олгогчийн дэмжлэгтэй ажлын виз зэрэг сэдвээр итгэмжлэгдсэн цагаачлалын хуульчид хандах хэрэгтэйг анхаарна уу.

Визийн төрлүүд	
F-1 болон J-1 статустай оюутнууд • Лиценз бүхий эмч, бариа засгийн эмч, итгэмжлэгдсэн клиникийн сэтгэл зүйч зэргийг тодорхойлолтоор хичээлийн ачаалал багасах хөнгөлөлт • Оюутан сургуулиа хаях болон түүнээс гарч болох үр дагавар • Хэрэв оюутан сургуулиас гарахаар шийдсэн бол сургалтын хөтөлбөрт буцаж орох тухай мэдээлэл • Дагалдагч гэр бүлийн хүний тухай боломж, нөхцлүүд • Визийн статус солихтой холбоотой ерөнхий мэдээлэл • U болон T визийн тухай ерөнхий мэдээлэл (Итгэмжлэгдсэн цагаачлалын хуульчид санал хүргүүлэх) • Итгэмжлэгдсэн хуульчид санал хүргүүлэх	H-1B, O-1, E-3, болон TN ажилтан • Ажилтан ажилаа таслах, үүний улмаас цагаачлалын статуст гарч болох үр нөлөө • Дагалдах гэр бүлийн хүний тухай боломж, нөхцлүүд • Визийн статус солихтой холбоотой ерөнхий мэдээлэл. Итгэмжлэгдсэн цагаачлалын хуульчид санал хүргүүлэх • U болон T визийн тухай ерөнхий мэдээлэл. (Итгэмжлэгдсэн цагаачлалын хуульчид санал хүргүүлэх) • Итгэмжлэгдсэн цагаачлалын хуульчид санал хүргүүлэх • АНУ-н Байнгын оршин суух эрх хүлээгдэж буй (ногоон карт хараахан батлагдаагүй) • Ажлаас гарснаар ажил олгогчийн-батлан даалттай байнгын оршин суух эрх хүссэн өргөдөлд гарах нөлөөлөл; • Итгэмжлэгдсэн хуульчид санал хүргүүлэх

Цагаачлалын хуульч гэж хэн болох юу хийдэг тухай?

Цагаачлалын хуульч гэдэг нь итгэмжлэгдсэн хуульч бөгөөд цагаачлалын хуулиар мэргэшсэн байна. Тэд үйлчлүүлэгчдийн зөвлөгч байхаас гадна цагаачлалын байгууллага, цагаачлалын шүүхийн өмнө үйлчлүүлэгчдийг төлөөлөхөөс гадна тэднд цагаачлалын хөнгөлөлт үйлчилгээ авахаар өргөдөл гаргана. Хуульчид үйлчлүүлэгчдэд ерөнхий зөвлөгөө өгөх, мөн цагаачлалын тухай боломжуудыг зөвлөлдөж болно. Бусад хуульчдийн нэг адил тэд мэргэжлийн ёс зүй, эрх зүйн шаардлагад нийцэж ажиллах бөгөөд үйлчлүүлэгчдийн ярианы нууцлалыг хадгалах ёстой.

Орон нутгийн цагаачлалын хуульч хаанаас олж болох вэ?

АНУ-н Иргэншил Цагаачлалын Алба (USCIS), Дотоодыг Аюулаас Хамгаалах Газар (DHS) байгууллагуудаас хувь хүмүүс үнэгүй болон бага төлбөртэй эрх зүйн туслалцаа олоход туслах хоёр вебсайтыг санал болгодог: USCIS: Орон нутгийн хүрээнд туслалцаа хайх вэбсайт USCIS: Эрхзүйн Үйлчилгээ Хайх Вэбсайт	
Цагаачлалын Давж заалдах шатны Зөвлөл (The Board of Immigration Appeals-BIA) байгууллагаас үнэгүй болон бага төлбөртэй хуульчдийн жагсаалтыг муж мужаар гаргасан байдаг.	
Америкийн Цагаачлалын Хуульчдийн Холбоо (AILA) байгууллагаас оюутнууд, судлаач оюутнууд цагаачлалын хуульч хайхад нь туслах зорилгоор онлайн хуульчид санал хүргүүлэх үйлчилгээ санал болгодог.	
Америкийн Хуульчдийн Холбооноос (The American Bar Association) мөн эрх зүйн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг муж түс бүрээр нь гаргасан байдаг.	